ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ГСА-2022/18/СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Говьсүмбэр аймаг<br>2022 он | Дарга тэргүүлэх аудитор:<br>Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn<br><br>Аудитын менежер:<br>Утас: 7054-3179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор:<br>Утас: 7054-3179 Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....14
3. Аудитын тайлан....15
3.1 Ерөнхий зүйл....15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....15
3.4 Материаллаг байдал ....16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....18
3.8 Аудитын гол асуудал ....18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....19
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд....19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй. ....19
4. Аудитын илрүүлэлт ....19
4.1 Залруулсан алдаа .... 19
4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй.... 20
4.3 Албан шаардлага .... 20
4.4 Зөвлөмж.... 20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2022.02.24 № 06

танай ____________-ны № ____________-т

АЙМГИЙН “УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Э.ЭНХ-ОД ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Ус, цаг уур, орчны шинжилгээний төв"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Ус, цаг уур, орчны шинжилгээний төв"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4202020017

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **65,350,440.70** | **68,674,044.11** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **10,000.00** | **0.00** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **10,000.00** | **0.00** |
| **31210** | **Төгрөг** | **10,000.00** | **0.00** |
| **33** | **АВЛАГА** | **0.00** | **2,000.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 2,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **65,340,440.70** | **68,672,044.11** |
| **35100** | **Түүхий эд материал** | **51,236,264.50** | **54,762,967.91** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 51,236,264.50 | 54,762,967.91 |
| **35400** | **Хангамжийн материал** | **14,104,176.20** | **13,909,076.20** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,055,660.00 | 884,560.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,048,516.20 | 13,024,516.20 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **706,410,386.53** | **739,739,076.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **706,410,386.53** | **739,739,076.06** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **119,208,386.53** | **151,962,631.62** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 43,754,425.28 | 56,754,425.28 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,698,756.48 | -2,548,134.72 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 72,600,906.78 | 62,767,573.78 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -24,148,273.80 | -17,373,425.32 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 107,959,899.81 | 80,957,555.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -92,735,137.59 | -39,150,365.05 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,289,260.00 | 19,609,260.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,495,431.56 | -13,961,088.35 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,862,926.40 | 11,945,752.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -7,181,432.31 | -7,038,921.28 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **587,202,000.00** | **587,776,444.44** |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 583,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -770,000.00 | -8,555.56 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 587,202,000.00 | 587,202,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **771,760,827.23** | **808,413,120.17** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **10,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **10,000.00** |
| **41300** | **Өглөг** | **0.00** | **10,000.00** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 2,000.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **0.00** | **8,000.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 8,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **771,760,827.23** | **808,403,120.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **771,760,827.23** | **808,403,120.17** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 719,077,507.53 | 719,077,507.53 |

| | | | |
|---|---|---|---|
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **48,142,105.41** | **84,784,398.35** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -4,893,326.05 | 48,142,105.41 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 53,035,431.46 | 36,642,292.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,541,214.29 | 4,541,214.29 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **771,760,827.23** | **808,413,120.17** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **311,947,318.98** | **295,877,904.76** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **87,626,181.98** | **58,832,221.76** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **87,626,181.98** | **58,832,221.76** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **100,000.00** | **100,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000.00 | 100,000.00 |
| 120009 | Бусад орлого | 10,000.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 57,581,373.78 | 43,036,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 29,934,808.20 | 15,696,221.76 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **224,321,137.00** | **237,045,683.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **220,960,100.00** | **218,579,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 220,960,100.00 | 218,579,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,361,037.00** | **18,466,083.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 190,827.00 | 15,481,783.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,170,210.00 | 2,984,300.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **258,911,887.52** | **259,235,611.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **258,911,887.52** | **259,235,611.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **252,568,427.80** | **258,505,081.59** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **173,744,961.15** | **177,633,437.63** |
| 210101 | Үндсэн цалин | 173,744,961.15 | 176,032,437.63 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 701,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 900,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **21,849,843.35** | **23,429,844.14** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,883,599.35 | 16,286,825.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,751,010.00 | 1,785,754.53 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,390,727.00 | 1,428,603.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 347,683.00 | 357,150.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,476,824.00 | 3,571,510.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **4,490,021.57** | **4,454,834.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,040,021.57 | 1,232,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,450,000.00 | 3,154,934.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 67,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **23,515,771.88** | **25,939,480.35** |
| 210401 | Бичиг хэрэг | 730,650.00 | 680,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,406,827.00 | 4,212,183.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 774,573.21 | 916,079.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 96,000.00 | 96,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 16,282,514.00 | 19,002,918.35 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,225,207.67 | 1,031,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **0.00** | **27,200.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 27,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **700,000.00** | **1,500,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 700,000.00 | 1,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,040,000.00** | **728,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,040,000.00 | 728,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,343,110.00** | **2,084,975.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 264,000.00 | 842,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 756,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 131,250.00 | 94,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 595,000.00 | 460,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 596,860.00 | 596,800.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0.00 | 10,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **23,884,719.85** | **22,707,310.47** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,000.00 | 0.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21,834,719.85 | 22,707,310.47 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,343,459.72** | **730,530.23** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **6,343,459.72** | **730,530.23** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,343,459.72 | 730,530.23 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **53,035,431.46** | **36,642,292.94** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **0.00** | **0.00** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **53,035,431.46** | **36,642,292.94** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **715,375,507.53** | **4,541,214.29** | **-4,893,326.05** | **715,023,395.77** |
| **2** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **715,375,507.53** | **4,541,214.29** | **-4,893,326.05** | **715,023,395.77** |
| **3** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **3,702,000.00** | **0.00** | **0.00** | **3,702,000.00** |
| **4** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **53,035,431.46** | **53,035,431.46** |
| **5** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **719,077,507.53** | **4,541,214.29** | **48,142,105.41** | **771,760,827.23** |
| **6** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **719,077,507.53** | **4,541,214.29** | **48,142,105.41** | **771,760,827.23** |
| **8** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **719,077,507.53** | **4,541,214.29** | **48,142,105.41** | **771,760,827.23** |
| **9** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **10** | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **11** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **12** | Өмчид гарсан өөрчилөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **13** | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **14** | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 36,642,292.94 | 36,642,292.94 |
| **15** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **719,077,507.53** | **4,541,214.29** | **84,784,398.35** | **808,403,120.17** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **224,431,137.00** | **237,145,683.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **110,000.00** | **100,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **110,000.00** | **100,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **100,000.00** | **100,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000.00 | 100,000.00 |
| 120009 | Бусад орлого | 10,000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **224,321,137.00** | **237,045,683.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **220,960,100.00** | **218,579,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 220,960,100.00 | 218,579,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,361,037.00** | **18,466,083.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 190,827.00 | 15,481,783.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,170,210.00 | 2,984,300.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **220,836,137.00** | **224,155,683.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **220,836,137.00** | **224,155,683.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **214,492,677.28** | **223,425,152.77** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **173,635,591.04** | **177,633,437.62** |
| 210101 | Үндсэн цалин | 118,726,506.12 | 128,375,812.59 |
| 210102 | Нэмэгдэл | 49,517,484.92 | 44,888,242.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,391,600.00 | 4,369,382.55 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **21,849,344.46** | **23,429,844.15** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,829,403.61 | 16,320,426.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,744,635.12 | 1,777,354.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,415,687.48 | 1,421,883.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 347,248.01 | 355,470.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,512,370.24 | 3,554,708.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **4,958,021.57** | **4,929,434.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,040,021.57 | 1,232,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,450,000.00 | 3,154,934.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 468,000.00 | 542,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,641,210.21** | **6,167,862.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,016,810.00 | 530,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,406,827.00 | 4,212,183.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 800,573.21 | 999,079.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 96,000.00 | 88,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 321,000.00 | 338,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **275,400.00** | **248,200.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 275,400.00 | 248,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **700,000.00** | **8,203,400.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 1,850,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 700,000.00 | 6,353,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,040,000.00** | **728,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,040,000.00 | 728,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,343,110.00** | **2,084,975.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 264,000.00 | 842,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 756,000.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 131,250.00 | 94,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 595,000.00 | 460,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 596,860.00 | 596,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,050,000.00** | **0.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,000.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,343,459.72** | **730,530.23** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **6,343,459.72** | **730,530.23** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,343,459.72 | 730,530.23 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **3,595,000.00** | **12,990,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **3,585,000.00** | **13,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,585,000.00** | **13,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **3,585,000.00** | **13,000,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,585,000.00 | 13,000,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-3,585,000.00** | **-13,000,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **10,000.00** | **-10,000.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 10,000.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 10,000.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **218,679,600.00** | **217,949,069.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **218,679,600.00** | **217,949,069.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **218,679,600.00** | **217,949,069.77** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **177,741,200.00** | **177,633,437.62** |
| 210101 | Үндсэн цалин | 128,376,600.00 | 128,375,812.59 |
| 210102 | Нэмэгдэл | 44,905,100.00 | 44,888,242.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,459,500.00 | 4,369,382.55 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **23,995,000.00** | **23,429,844.15** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,885,400.00 | 16,320,426.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,777,400.00 | 1,777,354.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,421,900.00 | 1,421,883.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 355,500.00 | 355,470.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,554,800.00 | 3,554,708.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **4,922,500.00** | **4,914,534.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,217,200.00 | 1,217,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,155,200.00 | 3,154,934.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 550,100.00 | 542,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,068,700.00** | **5,061,379.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 286,900.00 | 286,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,130,400.00 | 4,130,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 390,400.00 | 383,079.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 88,000.00 | 88,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 173,000.00 | 173,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **249,600.00** | **248,200.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 249,600.00 | 248,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,287,700.00** | **4,287,700.00** |
| 210604 | Урсгал засвар | 4,287,700.00 | 4,287,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **728,800.00** | **728,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 728,800.00 | 728,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,686,100.00** | **1,645,975.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 418,500.00 | 413,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 81,700.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 129,100.00 | 94,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 460,000.00 | 460,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 596,800.00 | 596,800.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **218,679,600.00** | **217,949,069.77** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **218,579,600.00** | **217,849,069.77** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 218,579,600.00 | 217,849,069.77 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **100,000.00** | **100,000.00** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000.00 | 100,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **31.00** | **31.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **15.00** | **15.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 14.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 0.00 | 0.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 0.00 | 0.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **15.00** | **15.00** |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 15.00 | 15.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **18,466,083.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **18,466,083.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **18,466,083.00** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **14,900.00** |
| **210301** | Гэрэл цахилгаан | 14,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,106,483.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 243,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 81,783.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернетийн төлбөр | 616,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 165,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **16,915,700.00** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 1,850,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,065,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **429,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 429,000.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **18,466,083.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **18,466,083.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,481,783.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,984,300.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн тогтвортой байдалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 тоо албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар” нь анхан шатны ажиглалтын чанарыг сайжруулах, Ус, цаг уур орчны шинжилгээний чанартай мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангах. гэсэн зорилт дэвшүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар” нь дотоод аудитын нэгж, ажилтныг томилоогүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 258,911.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,883.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 2,718.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,652.3 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмч дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 10.00 | | -10.00 |
| Авлага | | 2.00 | 2.00 |
| Бараа материал | 65,340.44 | 68,672.04 | 3,331.60 |
| Үндсэн хөрөнгө | 706,410.39 | 739,739.08 | 33,328.69 |
| **Нийт хөрөнгө** | **771,760.83** | **808,413.12** | 36,652.29 |
| Өр төлбөр | **0.00** | **10.00** | 10.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 771,760.83 | 808,403.12 | 36,642.29 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **771,760.83** | **808,413.12** | **36,652.29** |

Бараа материалын дансны үлдэгдэл 68,672.0 мянган төгрөг болж 3,331.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Цаг уур орчны шинжилгээний газраас 15,696.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлогыг хангамжийн материалын дансанд, төсвийн хөрөнгөөр 14,657.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, нийт 30,354.0 мянган төгрөгийн орлого бүртгэж, 1,031.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 27,022.4 мянган төгрөгийн материалыг зарцуулж 68,672.0 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 706,410.4 мянган төгрөг байсан ба тайлант хугацаанд Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 46 дугаар тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангаас 4,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2021 оны А/22 тоот тушаалын дагуу 275.0 мянган төгрөгийн нярвын санхүүгийн программ, 13,000.0 мянган төгрөгийн шугам хоолойг барилга байгууламж дансанд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 508 дугаар тогтоол, Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2021 оны А/18 дугаар тушаалын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 28 нэр төрлийн үндсэн хөрөнгийг 38,761.0 мянган төгрөгөөр үнэлэн бүртгэж, нийт 56,036.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогоор бүртгэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 508 дугаар тогтоол, Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2021 оны А/18 дугаар тушаалын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 28 нэр төрлийн 79,385.7 үндсэн хөрөнгийг данснаас хасаж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 220 дугаар тогтоол, Цаг уур орчны шинжилгээний газрын 2021 оны А/95 дугаар тушаалын дагуу 1,820.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устган 739,739.1 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнажээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 771,760.8 мянган төгрөгөөс 808,403.1 мянган төгрөг болж 36,642.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн байна.

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 16,069.4 мянган төгрөгөөр буюу 5.1 буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгө 28,794.0 мянга, улсын төсвийн санхүүжилт 2,380.5 мянга, нийт 31,174.5 мянган төгрөгөөр тус тус буурч нэмэлт санхүүжилтийн орлого 15,105.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 323.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 252,049.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 100.0 мянга, нийт 252,149.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 252,149.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 31,937.8 төгрөгөөр бууруулж, 220,211.4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд тайлант хугацаанд нийт 3 удаа төсөвт өөрчлөлт оруулж, жилийн эцсийн байдлаар 218,679.6 мянган төгрөгөөр санхүүжилтийг баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71408 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 218,679.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 218,579.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 100.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 218,579.6 мянган төгрөгийн санхүүжилт, 100.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг хүлээн авч, 217,949.1 мянган төгрөгийг зарцуулж, 730.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

| Хөтөлбөрийн код нэр | Арга хэмжээний код, нэр | Төлөв | Гүйц | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 71408-Цаг уурын шинжилгээ | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 218,261.1 | 217,535.6 | 725.5 |
| | 80220-Холбооны суваг ашигласны хөлс | 418.5 | 413.5 | 5.0 |
| **Нийт дүн** | | **218,679.6** | **217,949.1** | **730.5** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нэмэлт санхүүжилтийн дансаар Шүүхийн шинжилгээний албанаас холбооны сувгийн түрээс 165.0 мянга, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 2,000.0 мянга, Цаг уур орчны шинжилгээний газраас дулаан, цэвэр бохир усны шугамд холбох ажлын санхүүжилтэд 13,000.0 мянга, дата сим картын үнэ 550.0 мянга, цөлжилтийн эсрэг судалгааны төлбөрийн үлдэгдэл 81.8 мянга, автомашины хөдөлгүүрийн үнэ 1,850.0 мянга, шинжилгээний төлбөр 819.3 мянга, нийт 18,466.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 18,466.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үүнээс үндсэн үйл ажиллагааны орлого 819.3 мянган төгрөгийг эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүйгээр нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулсан зөрчил илэрсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцолсон.

### 3.8 Аудитын гол асуудал байхгүй

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний газар” нь 2021 онд нийт 270,639.6 мянган төгрөгийн 16 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Говьсүмбэр аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний газар” нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 3 сарын 25-ны 62 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,427.5 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 2,608.2 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 819.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" журмын 2 дугаар хавсралтын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгээгүй байсан тул завсрын аудитаар зөвлөмж өгч залруулсан.
2. Үндсэн хөрөнгийн тайланг дансны ангиллын дагуу улирал бүр буюу санхүүгийн тайланг гаргахаас өмнө бэлтгэж ирүүлээгүй байсныг завсрын аудитаар зөвлөмж өгч залруулсан.

3. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл нь аудит хийсэн тайлангаас орлогыг 1,145.4 мянгаар дутуу, зардлыг 2.3 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн байсныг аудитын явцад залруулсан.
4. Санхүүгийн үр дүнгийн тайланд 1,460.4 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлыг түлш халаалтын зардлаар тайлагнасныг аудитын явцад залруулсан.

**4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй.**

**4.3 Албан шаардлага**

1. Ажиллагсдад 17,372.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгохдоо тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж олгоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4,Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

2. Цахим төлбөрийн системд худалдан авалтын мэдээлэл тохирч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаагүй. Тухайлбал: 3 ААН-д шилжүүлсэн 902.5 мянган төгрөгийн төлбөрийн баримт цахим төлбөрийн системд шивэгдээгүй, 5 ААН-н 335.5 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг тус байгууллага руу илүү бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дах заалтыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

3. Байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас давсан орлогыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр зарцуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

28 нэр төрлийн 630.1 ширхэг 12,938.2 мянган төгрөгийн бараа материалыг дансны ангиллын дагуу бүртгээгүй тусгай зориулалтын материалын дансанд автомашины хөдөлгүүр, аж ахуйн материалын дансанд засвар, хангамж, цэвэрлэгээний материалыг бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20.2.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2 дугаар

хавсралтын 4.15, 4.21, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3.3.1.3.5 дах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу 1-ээс дээш жил ашиглах боломжтой барааг хангамжийн материалын дансанд бүртгэх, дансны ангиллыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар | 8 | 3,427.5 | 4 | 2,608.2 | | | 3 | 819.3 | 1 | |